



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2025 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 117

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сангийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 87,000,000.00 (наян долоон сая) төгрөгийн балансын үнэ, 38,968,750.00 (гучин найман сая есөн зуун жаран найман мянга долоон зуун тавь) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг Улсын драмын эрдмийн театрт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Улсын драмын эрдмийн театрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Наранбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгаж “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг авто тээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг бэлгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132000376  
6-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2025 оны ... дугаар сарын ... ны өдрийн  
 ... дугаар тогтоолын хавсралт

САНГИЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
 БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр, марк, улсын дугаар	Арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)		Үлдэгдэл өртөг	Хүлээн авах байгууллагын нэр
					Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)		
1	Тээврийн хэрэгсэл (Хьюндай Соната ДН-8 маркийн 03-68 УНД улсын дугаартай)	КМНЛ3416ВМ А119241	2020-12-31	87,000,000.00	38,968,750.00	48,031,250.00	Улсын драмын эрдмийн театр	
	Нийт дүн			87,000,000.00 (наян долоон сая)	38,968,750.00 (гучин найман сая есөн зуун жаран найман мянга долоон зуун тавь)	48,031,250.00 (дөчин найман сая гучин нэгэн мянга хоёр зуун тавь)		